<i>Зээлийн хүүгийн авлага</i>	9.5	6.7	-2.8
Эрүүл мэндийн төв: <i>/Төлбөртэй үйлчилгээний авлага/</i>	0.00	106.5	106.5
Орон нутгийн хөгжлийн сан: <i>/Байгууллагаас авах авлага/</i>	1.0	0.00	-1.0

Эх сурвалж: Тосонцэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тосон-Илч ХХК-ын татвар НДШ-ийн авлага болон байгууллагаас авах авлага 19.6 сая төгрөгөөр Цар тахлын үед үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний ЭМДС-аас авах 106.5

сая төгрөгөөр тус тус нэмэгдэж Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага 21.2 сая төгрөг, зээлийн хүүгийн авлага 2.8 сая төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

3.5.4 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат зээл, хувь хүмүүс олгосон зээл дансны эхний үлдэгдэл 15.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 10.7 сая төгрөг болж өмнөх оноос 4.9 сая төгрөгөөр буурсан байна.

3.5.6 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 403.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 532.2 сая төгрөг болж 129.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөг/

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засаг даргын Тамгын газар	42.0	56.4	14.4
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	0.9	0.9	0.00
Соёлын төв	15.6	16.9	1.4
Ерөнхий боловсролын сургууль	130.6	132.3	1.7
Тосон-Илч ХХК	20.3	31.4	11.2
Хүүхдийн цэцэрлэг	126.5	124.8	1.7
Эрүүл мэндийн төв	67.3	169.5	102.2
Нийт дүн	403.1	532.2	129.1

Эх сурвалж: Тосонцэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал дансны материаллаг өөрчлөлтөд ЗДТГ-ын бараа материал данс 14.4 сая төгрөгөөр, ЭМТ-ийн бараа, материал данс 102.2 сая төгрөгөөр тус тус нэгдэж нөлөөлсөн байна.

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 6,840.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 6,886.7 сая төгрөг болж 45.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт/-
Тосон-Илч ХХК	205.9	180.0	-25.9
Засаг даргын тамгын газар	1,198.1	1,264.3	66.2
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	0.4	4.3	3.8
Соёлын төв	112.7	100.7	-12.0
Сургууль	4,397.4	4,335.0	-42.4
Хүн эмнэлэг	245.7	294.1	48.5
Цэцэрлэг	680.6	688.3	7.6
Нийт	6,840.9	6,886.7	45.8

Эх сурвалж: Тосонцэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө олж бэлтгэсэн байдлыг авч үзвэл: Худалдан авсан 74.2 сая төгрөг, хандиваар 11.1 сая төгрөг, шилжүүлэн авсан 140.7 сая төгрөг, төсвийн хөрөнгө оруулалтаар 253.8 сая төгрөг, дахин үнэлгээ тогтоосон 36.4 сая төгрөг байна.

Хөрөнгийн зарлага болгосон байдлыг авч үзвэл: Акталж устгасан хөрөнгө 202.8 сая төгрөг, шилжүүлсэн хөрөнгө 128.5 сая төгрөг, дахин үнэлгээний хорогдол 52.4 сая төгрөг, тайлант онд байгуулсан элэгдлийн зардал 428.3 сая төгрөг, дахин үнэлгээний зөрүүнээс хамаарах элэгдэл 0.2 сая төгрөг байна.

Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгө 2021 оны эхний үлдэгдэл 182.2 сая төгрөг эцсийн үлдэгдэл 176.1 сая төгрөг байна. Тайлант онд ашиглалтгүй байгаа 10.6 сая төгрөгийн программ хангамж данснаас хассан, тайлант хугацаанд байгуулсан элэгдлийн зардал 0.1 сая төгрөг байна.

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 4.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 25.1 сая төгрөг болж 20.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Нийт төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Тосон-Илч ХХК	4.2	1.1	-3.1
Эрүүл мэндийн төв	0.00	24.0	24.0
Нийт дүн	4.2	25.1	20.9

Эх сурвалж: Тосонцэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Оны эцсийн өр төлбөр нь Тосон-Илч ХХК-ын татварын өглөг 4.1 сая төгрөг, урьдчилж орсон орлого 0.2 сая төгрөг, Эрүүл мэндийн төвийн бараа үйлчилгээний зардлын өглөг 24.0 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Засгийн газрын хувь оролцоо данс

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 7,687.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 8,199.0 сая төгрөг болж 511.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөгөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,614.4	1,614.4	0.00
Өмч /Төрийн/ ТӨҮГ	249.1	249.1	0.00
Хуримтлагдсан үр дүн	3,565.9	4,084.9	519.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,258.0	2,250.6	-7.4
Нийт дүн	7,687.4	8,199.0	511.4

Эх сурвалж: Тосонцэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хуримтлагдсан үр дүн дансанд тайлант үеийн үр дүн 521.7 сая төгрөгөөр өссөн нь орон нутгийн ерөнхий орлого 124.2 сая төгрөг, Тосон илч ХХК 117.4 сая төгрөг, Эрүүл мэндийн төв 233.3 сая төгрөгөөр материаллаг хэмжээгээр нөлөөлсөн байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс дахин үнэлэгдсэн үндсэн хөрөнгө данснаас хассаны зөрүү 7.4 сая төгрөгөөр буурсан байна.

3.5.10 Орлогын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үр дүнгийн тайлангаарх тайлант оны нийт орлогыг 4,374.5 сая төгрөгөөр тайлагнасан байна. Тайлант онд бүрдүүлсэн орлогыг өмнөх онтой харьцуулахад 3,140.4 сая төгрөгөөр буюу 58.2 хувиар буурсан байна.

Хүснэгт №7 Санхүүгийн үр дүнгийн нийт орлого

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Хувь
Татварын орлого	121.7	260.2	138.5	46.8
Татварын бус орлого	2,979.9	448,3	-2,531.6	-150.4



Тусламж санхүүжилтийн орлого	4,379.5	3,651.7	-727.8	-14.7
Үйл ажиллагааны бус орлогын дүн	7,481.1	4,360.2	-3,120.9	58.2
Үйл ажиллагааны бус орлого	33.8	14.3	-19.5	-42.3
Нийт орлогын дүн	7,514.9	4,374.5	-3,140.4	-58.2

Тайлант хугацааны орлогыг өмнөх үетэй зэрэгцүүлбэл: Татварын орлого 138.5 сая төгрөгөөр өссөн, татварын бус орлого 2,531.6 сая төгрөгөөр буурсан /татварын бус орлого буюу үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын үзүүлэлтээс шалтгаалж байна/, тусламж санхүүжилтийн орлого 727.8 сая төгрөгөөр буурсан байна.

3.5.11 Зардлын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангаар тайлант онд нийт **3,853.4** сая төгрөгийн зардал гаргасан, үүний 33.5 сая төгрөг нь үйл ажиллагааны бус зардал байна.

Хүснэгт №8: Санхүүгийн үр дүнгийн нийт зардал

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Хувь
Үйл ажиллагааны зардал	4,726.5	3,819.1	-907.4	-19.2
Үйл ажиллагааны бус зардал	99.3	33.5	-65.8	-25.6
Нийт дүн	4,825.8	3,853.4	-972.4	-15.8

Эх сурвалж: Тосонцэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант 2021 онд өмнөх оноос 972.4 сая төгрөгөөр бага зардал гаргаж ажилласан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хэмнэлтийн бодлогын талаар авах арга хэмжээний талаар” арга хэмжээний хэрэгжилтийг хянан үзэхэд сумын нийт зардлаас 16.8 сая төгрөгийг улс, орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Санхүүгийн нэгтгэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын 1,738.3 сая төгрөгийн орлого, зардлын давхардсан гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тосонцэнгэл сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар ТЭЗ-ийн өргөн мэдүүлсэн 2021 оны төсвийн төслийг хэлэлцэн 02 дугаар тогтоолоор сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 10 хөтөлбөрт зориулан 3,671.5 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Тосонцэнгэл сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн хуралдааны 4/03 дугаар тогтоолоор 2021 оны төсөвт тодотгол хийж 66.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж 3,737.7 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар дараах зохицуулалтыг хийсэн байна. Үүнд:

- Ерөнхий боловсролын сургууль 82.7 сая төгрөг нэмсэн
- Хүүхдийн цэцэрлэг 4.8 сая төгрөг хассан
- Соёлын төв 2.0 сая төгрөг нэмсэн
- Эрүүл мэндийн төв 15.0 сая төгрөг нэмсэн

Нийт 3,737.7 сая төгрөгийн зардлын 2,126.9 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 82.5 сая төгрөгийг ОНХНС-аас, 1,091.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 43.7 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 49.0 сая төгрөгийг сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс, 6.0 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос, урьд оны үлдэгдлээс 338.0 сая төгрөгөөр тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Сумын төсвийн орлого бүрдүүлэлт.

Тосонцэнгэл сумын ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөв батлах тухай 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 02 дугаар тогтоолд зааснаар Тосонцэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 110.2 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 292.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 265.8 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого	5.7	47.8	42.1	835
Хөрөнгийн орлого	28.3	38.5	10.3	36.3
Шууд бус орлого	10.6	0.5	-10.2	-50.6
Хөрөнгө борлуулсны орлого	0.0	4.5	4.5	
Бууны албан татвар	1.6	1.7	0.1	9.4
Малд ногдуулах албан татвар	0.00	100.4	100.4	
Улсын тэмдэгтийн хураамж	6.8	6.6	-2.8	-4.1
Түгээмэл тархацтай АМНАТ	0.5	6.9	6.5	1395
Газрын төлбөр	1.5	2.3	0.8	52.3
Дуудлага худалдаа	0.00	0.00	0.00	0.00
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	0.0	0.0	0.0	0.0
Ойн нөөц ашигласны төлбөр	31.1	43.8	12.7	40.7
Байгалын ургамлын нөөц ашигласны төлбөр	0.0	0.0	0.0	0.0
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.5	2.3	1.7	412
Татварын орлогын дүн	91.3	260.2	168.9	285.0
Торгуулийн орлого	8.4	18.9	10.6	225
Түрээсийн орлого	0.5	0.00	-0.5	
Хувьцааны ногдол ашиг	10.0	10.0	10.0	0.00
Бусад орлого	0.00	3.7	3.7	
Татварын бус орлогын дүн	18.9	32.7	10.6	225.9
Нийт орлогын дүн	110.2	292.9	182.7	265.8

Эх сурвалж: Тосонцэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Сумын орон нутгийн орлого 182.7 сая төгрөгөөр давж биелэхэд үйл ажиллагааны орлого, ойн нөөц ашигласны төлбөр, хөрөнгийн орлого давж биелсэн, малд ногдуулах албан татварын орлогыг төлөвлөөгүй байсан нь голлож нөлөөлсөн байна.

Малд ногдуулах албан татварын орлогыг төлөвлөөгүй нь шинээр хэрэгжиж байгаа хууль тогтоомжийг хэрэгжүүлээгүй, тооцоо судалгаагүй, орон нутгийн орлогыг үндэслэлтэй үнэн зөв төлөвлөөгөйтэй холбоотой байна.

Шууд бус орлого, 10.2 сая төгрөгөөр, түрээсийн орлого 0.5 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 2.8 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд аймагт төвлөрүүлэх орлогыг 156.6 сая төгрөгөөр төлөвлөж 195.0 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 38.4 сая төгрөг буюу 24.5 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №10: Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө гүйцэтгэл



№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Цалин хөлс түүнтэй адилтгах орлого	129.5	166.6	37.1
2	Үл хөдлөх хөрөнгийн татвар	3.5	3.4	-0.1
3	Газрын төлбөр	2.2	3.4	1.2
4	Авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татвар	16.0	16.2	0.2
5	Зам ашигласны төлбөр	5.4	5.4	0.0
6	Түрээсийн орлого	0.0	0.0	0.0
	Нийт дүн	156.6	195.0	38.4

Эх сурвалж: Тосонцэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 27.6 сая төгрөгөөр төлөвлөж 56.2 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж, 28.6 сая төгрөг буюу 103.6 хувиар давуулан биелүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №11: Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	2,9	15,0	-12.1
2	Дотоод бараа үйлчилгээний НӨАТ	21.7	38.1	-16.4
3	Агаарын бохирдлын төлбөр	3.0	3,1	-0,1
4	Нийт дүн	27.6	56.2	-28.6

Эх сурвалж: Тосонцэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Тусламж санхүүжилтийн орлогын талаар

Тайлант онд тусламж санхүүжилтийн орлогыг 3,737.7 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэл 3,446.4 сая төгрөгөөр буюу 92.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 10 хөтөлбөрт зориулан 3,737.7 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 3,302.9 сая төгрөгийг урсгал зардалд, 299.6 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 135.1 сая төгрөгийг эргэж төлөгдөх цэвэр зээлийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Төсвийн хуваарийн дагуу аймгаас авах санхүүгийн дэмжлэг 981.4 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг бүрэн санхүүжиж, тусгай зориулалтын шилжүүлэг 2,126.9 сая төгрөгийн санхүүжилт авч 92.8 хувийн гүйцэтгэлтэй, ОНХС-ын шилжүүлгээр 82.5 сая төгрөг авахаас бүрэн санхүүжиж харьяа байгууллагуудад санхүүжилтийг бүрэн олгож ажилласан байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн хүү болон эргэн төлөлтөөс 135.1 сая төгрөгийн санхүүжилт төлөвлөж гүйцэтгэлээр 39.0 сая төгрөгийн хүүгийн төлбөр болон зээлийн эргэн төлөлт төлөгдсөн байна.

Төсвийн зарлагын талаар:

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,403.9 сая төгрөг буюу батлагдсан зардлын төлөвлөгөөг 333.7 сая төгрөгөөр хэмнэж 91.1 хувьтай байгаа нь Засгийн газрын 2021 оны 43 тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” хэрэгжсэнтэй холбоотой зарим зардлыг хэмнэн ажилласантай холбоотой байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 4.3 сая төгрөг
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 7.2 сая төгрөг
- Байр ашиглалттай холбоотой зардал 0.4 сая төгрөг
- Хангамж, бараа материалын зардал 6.1 сая төгрөг
- Эд хогшил, урсгал засварын зардал 0.9 сая төгрөг



- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 1.8 сая төгрөг
- Бараа үйлчилгээний бусад зардал 6.8 сая төгрөг
- Хөрөнгийн зардал 216.2 сая төгрөг

Сум хөгжүүлэх сангаас 135.1 сая төгрөгийн зээл олгохоор төлөвлөж 39.0 сая төгрөгийн зээлийн олголт хийсэн байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 11.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт, 5.4 сая төгрөгийг улсын төвлөрүүлсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын 10 төсөл, арга хэмжээнд 122.3 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 83.4 сая төгрөгийн санхүүжилт олгож орон нутгийн хөгжлийн сангийн дансны үлдэгдэл 39.9 сая төгрөг байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 0.4 сая төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 52.6 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд олсон орлогоос 11.9 сая төгрөг, засаг даргын нөөц хөрөнгөнөөс 7.6 сая төгрөг, ЭМЯ, ЭМГ-аас Корона вирус-2019 цар тахалтай тэмцэх үйл ажиллагааны дэмжлэгт 249.7 сая төгрөг нийт 322.2 сая төгрөгийг орлогыг бүрдүүлжээ.

Дээрх нэмэлт санхүүжилтийн орлогуудыг удирдамж зориулалтын дагуу зарцуулж ажилласан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд тусгагдаагүй онцлог үйл ажиллагааг харуулбал. Үүнд: Корона вирус-2019 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангах, орон нутагт малын гоц халдварт өвчинтэй тэмцэх гэх мэт үйл ажиллагаа нь онцлог асуудал байна.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Аудитаар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг заасан хугацаанд байршуулаагүй, төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмээг хэрэгжүүлээгүйтэй холбоотой зөрчлүүд илэрсэн.

Тосонцэнгэл сумын орон нутгийн орлогод “Малд ногдуулах албан татварын орлого”-ыг төлөвлөөгүйгээс орлогын төлөвлөгөө 182.7 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Сумын эрүүл мэндийн төвийн дансны зарцуулаагүй үлдэгдэл 41.5 сая төгрөгийг Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7, Сангийн сайдын 2015 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.1 заалтын дагуу аймгийн төрийн санд татан төвлөрүүлээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх



дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 60 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл, 47 мэдээллийг хугацаанд нь, 11 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд: Төвлөрүүлэн захирагчийн шилэн данс цахим хуудаст мэдээлэх 1 дүгээр сарын мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянан үзэхэд Соёлын төв, ИТХ-ийн шилэн дансны мэдээллийг хугацаандаа бүрэн мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг бүрэн хэрэгжүүлж мэдээллийг тухай бүр мэдээлж

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Сангийн яамны удирдлага мэдээллийн систем дэх системд байгууллагуудын нэрийг үнэн зөв мэдээлээгүй, байгууллагын гэрчилгээний нэр, улсын бүртгэл дэх нэр, дүрмийн сангийн дүн зөрүүтэй байна. Тухайлбал: Хүн эмнэлэг, Тосон илч ХХК-г Тосон илч ОНӨҮГ, сургууль, цэцэрлэг гэж бүртгэсэн байна.

Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 1.7. Зээлдэгч зээлийг хугацаандаа төлөөгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд төлөөгүй зээлийн дүнгийн 0,5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр алданги төлнө. Алдангийн хэмжээг сумын Засаг дарга болон зээлдэгчтэй байгуулах зээлийн гэрээнд тодорхой тусгана” заалтын дагуу хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлд алданги тооцоогүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид өгсөн зөвлөмж биелэлтийг Төрийн аудитын байгууллагад ирүүлж 100 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сумын орлогын төлөвлөгөөг судалгаа тооцоонд үндэслэн боловсруулж малд ногдуулах албан татварын орлогыг бүрэн төлөвлөж, орон нутгийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр бүрэн биелүүлсэн эхийг, сум хөгжүүлэх сангийн зээлийн хугацаа хэтэрсэн зээлд алданги тооцож бүртгэсэн эсэхийг анхаарч үзэх нь зүйтэй.

4. Аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлого болон харьяа 6 төсвийн байгууллага, 1 орон нутгийн өмчит ХХК, 2 тусгай сангийн нийт 9 санхүүгийн тайлан, 8 төсвийн гүйцэтгэлийн тайлан нэгтгэгдсэн, 5 санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 4 санхүүгийн тайлан түүвэрт хамрагдсан байна.



№	Байгууллагын нэр	Аудитад хамрагдсан байдал	Аудитын дүгнэлт
1	Засаг даргын Тамгын газар	Дүгнэлт гарсан	Зөрчилгүй
2	Ерөнхий боловсролын сургууль	Дүгнэлт гарсан	Зөрчилгүй
3	Хүүхдийн цэцэрлэг	Дүгнэлт гарсан	Зөрчилгүй
4	Эрүүл мэндийн төв	Дүгнэлт гарсан	Зөрчилгүй
5	Тосон илч ХХК	Дүгнэлт гарсан	Зөрчилгүй
6	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	Түүвэрт хамрагдсан	
7	Соёлын төв	Түүвэрт хамрагдсан	
8	Сум хөгжүүлэх сан	Түүвэрт хамрагдсан	
9	Орон нутгийн хөгжлийн сан	Түүвэрт хамрагдсан	

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 472.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 55.0 сая төгрөгийн зөрчил, харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд 26.6 сая төгрөгийн алдаа залруулж 390.7 сая төгрөгийн зөрчил /шилэн дансны нийцэлтэй холбоотой 325.6 сая төгрөг/ байна. Аудитаар илэрсэн зөрчилд 3 зөвлөмж өгч ажилласан болно.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар залруулсан алдаа байхгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно

4.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй байна.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Эрүүл мэндийн төвийн төрийн сангийн үндсэн санхүүжилтийн дансанд байршиж байгаа 41.5 сая төгрөгийн үлдэгдлийг аймгийн төрийн санд татан төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7, Сангийн сайдын 2015 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.1 “Төсвийн тухай хуулийн 7.7, 44.6-г үндэслэн төсвийн жил дуусахад улсын төсвийн байгууллагын зарцуулаагүй дансны үлдэгдлийг улсын төсвийн дансанд, орон нутгийн төсвийн байгууллагын үлдэгдлийг тухайн орон нутгийн төсвийн дансанд, нийгмийн даатгалын төсвийн байгууллагын зарцуулаагүй дансны үлдэгдлийг нийгмийн даатгалын сангийн төсвийн дансанд оны сүүлийн ажлын өдрийн банк хоорондын сүлжээгээр хамгийн сүүлийн орлого татсаны дараа төрийн сангууд шууд татан төвлөрүүлнэ” заалттай тус тус нийцэхгүй, тасалбар болголт, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Төрийн сангийн төлбөр тооцооны журамд зааснаар төрийн сангийн дансны үлдэгдлийг төвлөрүүлж байх.

2. Сум хөгжүүлэх сантай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Сум хөгжүүлэх сангаас 135.1 сая төгрөгийн зээл олгохоор төлөвлөж 39.0 сая төгрөгийн зээлийн олголт хийсэн байна. Зээлийн үлдэгдэлд хугацаа хэтэрсэн 58.4 сая төгрөгийн зээл, 6.7 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн авлага байна. Энэ нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 4.2.2. “Сум хөгжүүлэх болон жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх” заалттай нийцэхгүй эрх ба үүрэг батламж мэдэгдлийг байна.



2.2 Өгсөн зөвлөмж: Тайланд батлагдсан хэмжээгээр зээлийн олголт хийж төсвийн гүйцэтгэл ханган ажиллах, хугацаа хэтэрсэн 65.1 сая төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлагыг төлүүлэх талаар бодитой арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

3. Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлттэй холбоотой асуудал:

3.1 Илрүүлэлт: Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөнд малд ногдуулах албан татварын орлогыг төлөвлөөгүй, шууд бус орлого 10.2 сая төгрөгөөр, түрээсийн орлого 0.5 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 2.8 сая төгрөгөөр нийт 3 төрлийн орлого 13.5 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Орон нутгийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр судалгаа тооцоог үндэлсэн бодитой төлөвлөж биелэлтийг нэр төрлөөр ханган ажиллаж байх.

4. Харьяа байгууллагын санхүүгийн тайланд гарсан алдаа, зөрчилтэй холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт: Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 352.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 325.6 сая төгрөг, залруулсан алдаа 26.6 сая төгрөг байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг бүрэн хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

4.2 Өгсөн зөвлөмж: Аудитаар илэрсэн зөрчлийг арилгах зөвлөмжийг төсвийн шууд захирагч нарт хүргүүлсэн тул хэрэгжилтэд анхаарч ажиллан, зөвлөмжийн биелэлтийг нэгтгэн ирүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
			Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал										
Тосонцэнгэл сумын ТТЗ	1	55.0							1	55.0
Харьяа байгууллагууд										
Тосонцэнгэл сумын ЗДТГ	1	0.2	1	0.2						
Эрүүл мэндийн төв	2	26.4	2	26.4						
Тосон илч ХХК	2	0.0							2	0.0
Тосонцэнгэл сумын сум хөгжүүлэх сан	1	65.1							1	65.1
Дүн	7	146.7	3	26.6					4	120.1
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал										
Тосонцэнгэл сумын ЗДТГ	1	314.6							1	314.6
Тосонцэнгэл сумын Эрүүл мэндийн төв	1	0.0							1	0.0
Тосон илч ХХК	1	11.0							1	11.0
Дүн	3	325.6							3	325.6
Нийт дүн	11	472.3	3	26.6					8	445.7

